



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-12

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

Аэродром - Гэрчилгээжүүлэлт, Үйл ажиллагаа болон

UNICOM болон AWIB үйлчилгээний хэрэглээ

2022 оны 12 сарын 9

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэ АС нь UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа үйлчилгээ үзүүлэгчид болон нисэхийн радио холболтод үндсэн радио холбоогоор хангадаг хүмүүст зориулсан дүрмийн зорилгыг тодруулах зорилготой юм. АС нь, үйлчилгээ нь UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ мөн эсэхэд зөвлөгөө өгөх болон ИНД-139-ийн дагуу UNICOM болон AWIB үйлчилгээний шаардлагыг мөрдөж байгааг харуулах Даргын хүлээн зөвшөөрөхүйц ерөнхий зөвлөмжийн мэдээлэл болон аргачлалаар хангана.

Холбогдох дүрмүүд

Энэхүү АС нь ИНД-139-ийн F Бүлэгт холбоотой болно.

Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын ИНД-ийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

АС139-8-ыг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална

АС139-8-ыг NZ АС139-8-ын 2007 оны 4 сарын 27-ны өөрчлөлт 2-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

Танилцуулга	4
Дүрмийн хэрэгжилт	5
Тодорхойлолт	5
Бүлэг 1. Нэмэлт, өөрчлөлт	5
Товчлол	7
Аэродром - Гэрчилгээжүүлэлт, Үйл ажиллагаа болон Ашиглалт	7
А Бүлэг - Ерөнхий зүйл	7
GM 139.1-Зорилго	7
Б Бүлэг - UNICOM болон AWIB Үйлчилгээ	7
139.351- UNICOM болон AWIB үйлчилгээний хангалт	8
GM 139.351 (a) болон (b) - Ерөнхий хязгаарлалт.....	8
GM 139.351 (c) Үйлчилгээ тус бүрийн хязгаарлалт.....	8
139.353 - UNICOM болон AWIB үйлчилгээний шаардлага, Үйлчилгээ үзүүлэгч болон үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага.....	8
AMC 139.353 (a)(1) - Дуудлага	9
AMC 139.353 (a) (2)-Холбооны давтамжийн зөвшөөрөл.....	9
AMC 139.353 (a)(3) - Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөл	9
AWIB болон UNICOM үйлчилгээний шаардлага.....	9
AMC 139.353 (b)(1 болон 2)-Үйл ажиллагааны шаардлага.....	9
AMC 139.353 (b)(3) - ICAO системийн шаардлагын хэрэгжилт.....	9
AMC 139.353 (b)(4) - ICAO холбооны журмын хэрэгжилт	10
GM 139.353 (c)(1) - Алдаатай, эсхүл төөрөгдүүлэх дамжуулалт	10
AMC 139.353 (c)(2) - Үргэлжлүүлэн дамжуулах	10
GM 139.353 (c)(3) - Нислэгийн хөдөлгөөн, эсхүл цаг уурын үйлчилгээний зөрчил.....	10
GM 139.353 (d)(1) - Алдаатай, эсхүл төөрөгдүүлэх дамжуулалтаас урьдчилан сэргийлэх..	11
GM 139.353 (d)(2) - Алдаатай дамжуулалт гэж үзсэн үеийн үйлчилгээг цуцлах	11
GM 139.353 (d)(3) - Цаг агаарын мэдээний минимум шаардлага	11
UNICOM Үйлчилгээ.....	11
GM 139.353 (e)(1)-(7) - UNICOM Үйлчилгээ	11
GM 139.353 (e)(1) - Цаг агаарын мэдээ	12
GM 139.353 (e)(2) - Ашиглахаар сонгосон хөөрч бүүх зурвас	12
AMC 139.353 (e)(3) - Нислэг дагах хяналтын үйлчилгээ	13
AMC 139.353 (e)(4) - Онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг эхлүүлэх.....	13
GM 139.353 (e)(5) - Аэродромын давтамжид хариулах нэгж /AFRU/.....	13
GM 139.353 (e)(6) - Агаарын хөлгийн байрлалын талаарх мэдээлэл хүсэх.....	13
Хүлээн зөвшөөрөхүйц бус	14
GM 139.353 (e)(7) - Аэродромын мэдээлэл	14
GM 139.353 (f)-UNICOM хязгаарлалт	15
AMC 139.353 (g)- UNICOM ажилтанд тавих шаардлага	15
AWIB үйлчилгээ	16
GM 139.353 (h)(1)-(5)- Цаг агаарын үндсэн мэдээ.....	16

GM 139.353 (h)(6)- Ашиглахаар сонгосон хөөрч буух зурвас	16
GM 139.353 (h) (7)-Аэродромын мэдээлэл	16
UNICOM үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага.....	17
GM 139.355 (a)- UNICOM үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага	17
AMC 139.355 (a)(1)- Холбооны журам.....	17
AMC 139.355 (a)(2) - Санал болгосон үйлчилгээний шаардлагыг хангах сургалт.....	17
AMC 139.355 (a)(3) - Эрхийн хүрээний баталгаа.....	18
Үйлчилгээний мэдээлэл.....	18
GM 139.357-AIS мэдээллийн үйлчилгээ	18
AIS -тай холбоо барих хаяг	18
GM 139.357 (a)(1) - Станцын тодорхойлолт	19
GM 139.357 (a)(2) - Аэродромын тодорхойлолт	19
GM 139.357 (a)(3) -Үйлчилгээний цаг	19
GM 139.357 (a)(4) - Үйлчилгээний хангалт	19
GM 139.357 (a)(5)- Үйл ажиллагааны бусад холбогдох мэдээлэл	19
GM 139.357 (a)(6)- Захиргааны мэдээлэл.....	19
Шилжилтийн зохицуулалт	19
GM 139.359- Шилжилтийн зохицуулалт	19
Хавсралт А	20
Annex 10 Vol II-ын Холбогдох хэсгийн гарчиг	20
Хавсралт В.....	22
UNICOM Үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчийн сургалт	22
UNICOM Үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч - Сургалтын хөтөлбөр	22
Unicom үйлчилгээний сургалтын модуль	22
Сургалтын модулийн сэдвийн задаргаа	23
Түвшин Нэг - Аэродромтой танилцах.....	23
Түвшин Хоёр - Баримт бичиг болон Хамтын гэрээ.....	23
Түвшин Гурав - Unicom үйлчилгээний үндсэн сургалт	24
Түвшин Дөрөв - Аэродромын үзлэг.....	24
Түвшин Тав - Цаг агаар.....	25
Түвшин Зургаа - Цаг агаарын болон мэдээллийн автоматжуулсан дамжуулалт	25
Хавсралт С.....	28
Аэродромын давтамжид хариулах нэгж	28
Онцлог шинж чанар	28
Хавсралт D	30
Холбооны журам.....	30
Радио- холбооны үйл ажиллагааны тэмдэглэл.....	30
Үзүүлж байгаа үйлчилгээний хүснэгт	32

Танилцуулга

АС 139-12 нь иргэний нисэхийн салбарын дүрмийн Зөвлөх болон Техникийн судалгааны хэсэг Монгол улсад UNICOM болон AWIB үйлчилгээ эрхлэгчдийн холбогдох шаардлагыг боловсруулах ажлын нэгдсэн үр дүн юм. Энэхүү АС нь ИНД-139 F Бүлгийн холбогдох шаардлагын ойлголтыг өгөх болно.

UNICOM болон AWIB үйлчилгээ нь хяналтгүй аэродром дээр нисэхийн холбогдох тоноглолоор хангах үйлчилгээ юм. Аль ч үйлчилгээ нь ИНД-ийн дагуу гэрчилгээжилт шаарддаггүй боловч ИНД-139 F Бүлэг-т заасан шаардлагыг хангах ёстой.

А UNICOM үйлчилгээ нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ биш аэродромын үндсэн үйлчилгээ юм. IFR болон VFR-аар нислэг үйлдэх агаарын хөлгийн нисгэгч нь агаарын хөлгийн үйл ажиллагааны хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Мэдээллийн хэрэглээ болон нислэгийн аюулгүй байдлыг үргэлжлүүлэн хангах үүднээс нисгэгч нь хүлээн авсан мэдээллийг зөвшөөрөх болон татгалзах шийдвэр гаргах шаардлагатай.

Дээрх давтамжийн үйл ажиллагаа болон үйлчилгээ явуулдаг хоёр мэдээллийн үйлчилгээ нь AIP-д зарлагдсан байна.

UNICOM бол “Universal Communications”, эсхүл АНУ-ын Нийтлэг холбооны товчилсон үг бөгөөд Монгол Улсад:

- агаар/газар холбооны үйлчилгээ, хяналтгүй аэродром дээр, эсхүл хяналтгүй аэродром дээр байдаг аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний мэдээллийн агуулгыг нэмэгдүүлэх.
- аэродромын орчимд нисгэгч болон талбай дээрх бусад ажилтанд өгөх хязгаарлагдмал мэдээллийг дамжуулах үйлчилгээ.
- нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ биш бөгөөд нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангах боломжгүй.
- үйл ажиллагаа эрхлэгчийн анхаарч байгаа агаарын хөлгийн ерөнхий байршлыг хүсэлтийн дагуу өгөх үйлчилгээ гэхдээ нисгэгчийн өмнөөс ямар нэгэн дүн шинжилгээ, эсхүл тайлбар хийдэггүй.

AWIB бол аэродромын болон цаг агаарын мэдээлэл дамжуулахад зориулсан үгийн товчлол бөгөөд тойм мэдээллийн автоматжуулсан дамжуулалт юм. Мэдээллийг автоматаар, эсхүл гараар цуглуулдаг. AWIB үйлчилгээ нь эзэнгүй аэродромыг мэдээллээр хангадаг бөгөөд UNICOM үйлчилгээтэй давхцан хангагдах боломжтой. Эдгээр нь цаг агаарын болон бусад үйл ажиллагааны мэдээллээр хангахаар зориулагдсан.

Мэдээллийн дамжуулалт нь автоматжуулсан мэдрэгч, бодит ажиглалт, эсхүл дээрх хоёрын хослолоос түүвэрлэгдэх бөгөөд байршлын хувьд өөр өөр байх боломжтой.

Тухайн аэродром, эсхүл газарт цаг агаарын бодит нөхцөлд хийсэн үгэн тайлбар бүхий цаг агаарын үндсэн мэдээ нь UNICOM болон AWIB үйлчилгээ хоёуланд нь багтсан байдаг. Цаг агаарын мэдээг ИНД-174-д тодорхойлсон болно.

Цаг агаарын үндсэн мэдээ нь дараах зүйлсийг агуулсан байна:

- нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх цаг агаарын үндсэн аман мэдээний хангалт

- агаарын хөлөг болон бусад нисэхийн холбогдох хэсгүүдийн хоорондох цаг агаарын одоогийн нөхцөлийн аман тайлбар.

Тэмдэглэл:

- цаг агаарын үндсэн мэдээ болон AWIB нь цаг уурын мэдээллийн ялангуяа нислэгийн үйл ажиллагааг явуулахад болон ердийн төлөвлөлтийг хийхэд шаардлагатай цаг уурын мэдээллийн нөөц хувилбар биш юм.

Энэ дэд хэсгийн заалтад хамааралтай байснаар, AWIB болон UNICOM үйлчилгээний цаг агаарын үндсэн мэдээ болон цаг уурын мэдээний үйлчилгээ нь ИНД-174-д хамаарна. 174.6-гийн шаардлага нь ажиглалтын төхөөрөмж, тэдгээрийг шалгах, энэхүү мэдээллийг хангах ажилтны сургалт зэргийг агуулсан болно.

Дүрмийн хэрэгжилт

Дүрмийн хэрэгжилтийн гарын авлага нь энэхүү хэсэгт багтсан бөгөөд дүрэмд тайлбар шаардлагагүй үед дараагийн холбогдох материалаар хангана.

Тодорхойлолт

Бүлэг 1. Нэмэлт, өөрчлөлт

ИНД-139 F Бүлэг, UNICOM/AWIB үйлчилгээнд хэрэглэдэг нэр томъёоны тодорхойлолт нь дараах хэсэгт байгаа товчлол бөгөөд ерөнхийдөө дүрэмд байдаг, хэрэглэдэг үгс болно.

1. Энэ хэсэгт байдаг тодорхойлолт нь онцгой бөгөөд UNICOM/AWIB үйлчилгээний F Бүлэгт ямар нэгэн нэр томъёо байдаггүй болно. Хэрэглэхэд тохиромжтой байлгах үүднээс ихэнх хамааралтай нэр томъёо дахин хэрэглэгдэж байгаа болно.

Аэродромын давтамжид хариулах нэгж / Aerodrome frequency response unit гэж агаарын хөлгөөс модуляцлагдсан VHF дамжуулалтыг тохирох давтамж дээр хүлээн авч, тухайн нисгэгчийн радио давтамжийн сонголтыг бататгах зорилгоор дуугаар, эсхүл дууны өнгөөр, эсхүл аль алиныг нь хослуулан хариуг автоматаар дамжуулдаг газрын VHF радиог.

Нисэхийн байгууламж / Aeronautical facility гэж:

- (1) IFR нислэг, эсхүл НХҮ-г дэмждэг, нисэхийн радио нэвтрүүлгийн, эсхүл нисэхийн суурин холбооны үйлчилгээнд ашигладаг холбооны төрөл бүрийн системийг; эсхүл
- (2) нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашигладаг, холбооны төрөл бүрийн системийн газрын элементийг; эсхүл
- (3) нисэхийн радио навигацийн үйлчилгээнд ашигладаг төрөл бүрийн радио навигацийн туслах төхөөрөмжийг; эсхүл
- (4) IFR нислэг, эсхүл НХҮ-г дэмждэг газрын холбооны бусад системийг; эсхүл

- (5) нисэхийн хөдөлгөөнт холбооны радио давтамж дээр ажилладаг, цаг агаарын үндсэн мэдээлэл, орон нутгийн аэродромын мэдээ, эсхүл нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг газрын холбооны төрөл бүрийн системийг.

Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ / Aeronautical mobile service гэж нисэхийн холбооны станц болон агаарын хөлгийн станцын хооронд, эсхүл агаарын хөлгийн станц хоорондын холбооны хөдөлгөөнт үйлчилгээг; үүнд аврах хэрэгслийн станц багтаж болно. Мөн аюулын болон ослын мэдээлэл дамжуулах тогтоосон давтамж дээр ажилладаг ослын байршил заагч радио дохиологч станц багтаж болно.

Нисэхийн холбооны станц / Aeronautical station гэж нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний газрын станцыг.

Нислэгийн хөдөлгөөн / Air traffic гэж нислэгт байгаа, эсхүл аэродромын маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бүх агаарын хөлгийг.

Алтиметрийн тохируулга QNH / Altimeter setting гэж газарт байхдаа тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтаар тохируулдаг ба далайн дундаж түвшний 1013.25 hPa (760 мм м.у.б) даралт болон 1000м тутамд 6.5°C-ийн буурах хурдтай 15°C хэмд тодорхойлсон, ICAO-гийн Стандарт Атмосферийн дагуу далайн дундаж түвшин хүртэл багасгасан тухайн аэродромын түвшний даралтыг.

AWIB үйлчилгээ / AWIB service гэж тусгайлан нисэхийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор аэродромын болон цаг уурын мэдээгээр хангадаг автомат радио нэвтрүүлгийг, AWIB үйлчилгээ нь НХУ биш.

Цаг агаарын үндсэн мэдээ / Basic weather report гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд ажиглагдсан дараах цаг агаарын бодит нөхцөлийг тодорхойлж байгаа аман мэдээллийг:

- (1) салхины чиглэл ба хүч;
- (2) далайн дундаж түвшний агаарын даралт;
- (3) агаарын хэм;
- (4) цаг агаарын нөхцөл болон үүлшил;

Радио нэвтрүүлэг / Broadcast гэж бүх станц хүлээн авахад зориулсан дамжуулалтыг.

Цаг уурын үйлчилгээ / Meteorological service гэж нисэхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор цаг уурын мэдээгээр хангадаг дараах үйлчилгээг:

- (1) Уур амьсгалын мэдээний үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайд зориулан уур амьсгалын мэдээ боловсруулах болон хангах үйлчилгээ;
- (2) Урьдчилан мэдээлэх үйлчилгээ: тодорхой газар нутаг, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан цаг уурын урьдчилсан мэдээгээр хангах үйлчилгээ;
- (3) Мэдээлэл түгээх үйлчилгээ: цаг уурын мэдээг цуглуулах болон түгээх үйлчилгээ;
- (4) Цаг уурын зааварчилгаа өгөх үйлчилгээ: цаг уурын одоогийн болон таамаглаж байгаа нөхцөлийн талаарх цаг уурын мэдээг бичгээр болон амаар тайлбарлан мэдээлэх үйлчилгээ;
- (5) Цаг уурын мэдээллийн үйлчилгээ: цаг уурын тогтмол мэдээллээр хангах үйлчилгээ;
- (6) Цаг уурын ажиглалтын үйлчилгээ: тодорхой газар нутаг дахь агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд ажиглалт хийх үйлчилгээ;

Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл / Traffic information гэж тухайн байршил, эсхүл төлөвлөсөн нислэгийн замын ойр байж болох, мэдэгдэж байгаа, эсхүл ажиглагдсан нислэгийн хөдөлгөөнийг нисгэгчид анхааруулж, мөргөлдөхөөс зайлсхийхэд нисгэгчид туслах зорилгоор НХҮ-ний нэгжээс өгдөг мэдээллийг.

UNICOM Үйлчилгээ / UNICOM Service гэж нисэхийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор орон нутгийн аэродромыг мэдээллээр хангах, нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний газрын радио холбооны үйлчилгээг; UNICOM нь НХҮ биш.

Товчлол

AFRU - Аэродромын давтамжийг хариулах нэгж.

AWIB - Аэродромын болон цаг агаарын мэдээ дамжуулагч.

BWR - Цаг агаарын үндсэн мэдээ

QNH - Алтиметрийн тохируулга.

Аэродром - Гэрчилгээжүүлэлт, Үйл ажиллагаа болон Ашиглалт

А Бүлэг - Ерөнхий зүйл

GM 139.1-Зорилго

139.1 нь дүрмийн зорилго бол шаардлагын танилцуулга гэдгийг тодорхой үзүүлсэн баримт бичиг юм. UNICOM болон AWIB үйлчилгээний үйл ажиллагаа болон хангалтанд зориулсан шаардлагын танилцуулгыг харуулсан Бүлэг мөн орсон болно.

F Бүлэг - UNICOM болон AWIB Үйлчилгээ

ИНД-139 F Бүлэг нь ерөнхийдөө нисгэгчид хэрэглэх боломжтой ба дамжуулагддаг UNICOM болон AWIB үйлчилгээний тодорхойлолтод хамаардаг үйлчилгээний хангалт болон үйл ажиллагааны шаардлагыг заасан.

139.353(c)(1)-(7), эсхүл 139.353(h)(1)-(7)-д заасан үйлчилгээнээс аль нэгийг нь эрхэлдэг этгээд ИНД-139 F Бүлэгт заасан шаардлагыг зайлшгүй хангасан байна.

Энэ дүрмийн Дэд бүлэгт хэрэглэдэг нэр томъёоны тодорхойлолт нь ерөнхийдөө Бүлэг 1-д заасан товчлолын дагуу дүрэмд байдаг, хэрэглэдэг үгс болно. Энэхүү Бүлэгт хамаарах онцгойлсон тодорхойлолт бүхий нэр томъёо байхгүй болно.

139.351- UNICOM болон AWIB үйлчилгээний хангалт**GM 139.351 (a) болон (b) - Ерөнхий хязгаарлалт**

F Бүлгийн дагуу холбогдох шаардлагыг хангаагүй нөхцөлд UNICOM болон AWIB үйлчилгээний үйл ажиллагаа болон хангалт үзүүлэхийг энэ Дүрмээр хориглоно.

F Бүлэгт заасан хяналт нь үйл ажиллагаагаа хялбаршуулах зорилгоор байгууллага өөрийн радио холбооны систем ашиглах, эсхүл ихэвчлэн бусад нисгэгч хэрэглэх боломжгүй хувийн радио станцыг нэвтрүүлэх зорилгогүй болно. Түүнчлэн цаг агаарын үндсэн мэдээгээр хангах хяналтын этгээдэд зориулагдаагүй болно.

Annex 10-ын хүрээнд хэрэгжүүлэх шаардлага нь мэргэжлийн холбооны зориулалтын гэдгийг болон радио төхөөрөмж нь нисэхийн холбооны үйл ажиллагаанд тохиромжтой болохыг баталгаажуулах үндсэн шаардлага юм. Нисэхийн холбооны дамжуулалтын үед ашиглах мэдээллийн өгөгдөл мөн байдаг.

Annex 10 Vol II, Chapter 5-т нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний радио холбоо болон Chapter 7 нь нисэхийн холбооны дамжуулалтын ижил төстэй стандарт болон зөвлөмжийн туршлагыг агуулсан байдаг. Эдгээр нь UNICOM болон AWIB үйлчилгээнд хэрэглэгдэх боломжтой болно.

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн аэродром дээр нэгээс илүү UNICOM болон AWIB үйлчилгээ байж болохгүй. Мөн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн аэродром дээрх төхөөрөмжид тавьдаг холбогдох хяналтын үйл ажиллагаатай эсэхийг баталгаажуулах, UNICOM, эсхүл AWIB үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс холбогдох зөвшөөрлийг заавал авсан байна.

Тэмдэглэл: UNICOM болон AWIB үйлчилгээний цаг агаарын мэдээг мэдээлэх нь тэдгээрийн хамгийн чухал үйл ажиллагаа бөгөөд 174.6-гийн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд хэрэв үйл ажиллагаа эрхлэгч нь цаг уурын мэдээлэл дамжуулахыг хүсвэл ИНД-174-ийн дагуу холбогдох гэрчилгээг авсан байна.

GM 139.351 (c) Үйлчилгээ тус бүрийн хязгаарлалт

Дүрмийн энэ дэд хэсэг нь тухайн аэродром дээр хийгдэж байгаа үйлчилгээний тоонд хязгаарлалт тавьдаг. Энэ нь бүх агаарын хөлөг холбооны ижил давтамж дээр үйл ажиллагаа явуулж байгааг баталгаажуулах аюулгүй байдлын шаардлага юм.

139.353 - UNICOM болон AWIB үйлчилгээний шаардлага, Үйлчилгээ үзүүлэгч болон үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

Дүрэм нь AWIB, эсхүл UNICOM үйлчилгээний үйл ажиллагааг эхлэхээс өмнө хэрэгжүүлэх ёстой шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарлана. AWIB болон UNICOM үйлчилгээнд хамаарах ерөнхий шаардлагыг агуулдаг бөгөөд үйлчилгээ тус бүрийн холбогдох шаардлага мөн орсон. Тусгайлсан үйлчилгээний хангалтын талаарх мэдээлэл нь тухайн үйлчилгээ эхлэхээс өмнө хамгийн багадаа 90 хоногийн өмнө AIP-д зарлагдсан байна гэсэн заалт нь 139.357-д дурдагдсан. Тиймээс холбооны дуудлага нэр болон холбооны давтамжийн зөвшөөрөл зэргийг авах болон зарлах хоорондын хугацааг тооцсон байна.

АМС 139.353 (а)(1) - Дуудлага

AWIB, эсхүл UNICOM үйлчилгээний үйл ажиллагааг эхлэхээс өмнө дуудлага нэрийг ИНЕГ-ын САА24171/02 маягтийн дагуу хүргүүлснээр авна. ИНЕГ-ын маягт нь НААХЗА-ны албаны цахим хуудаснаас авах боломжтой. Цахим хуудасны хаяг <http://srd.mcaa.gov.mn//index.php>.

АМС 139.353 (а)(2)-Холбооны давтамжийн зөвшөөрөл

Нисэхийн радио холбооны давтамжийг олгох, ашиглах асуудлыг Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцдаг болно. Нисэхийн радио холбооны давтамжаар UNICOM болон AWIB үйлчилгээ үзүүлэх үед радио төхөөрөмжийг Харилцаа холбооны зохицуулах газар болон ИНЕГ-аас гэрчилгээжүүлнэ.

Дээрх үйлчилгээг эхлүүлэхээс өмнө радио холбооны төхөөрөмжийг ИНЕГ-аас гэрчилгээжүүлсэн байна. Тавих шаардлагын мэдээлэл болон хүсэлт гаргах маягтыг ИНЕГ-ын доорх цахим хуудаснаас авах боломжтой. <http://srd.mcaa.gov.mn//index.php>

АМС 139.353 (а)(3) - Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөл

ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь эрэн хайх авран хамгаалах үйлчилгээ, апроны менежмент болон Дарга шаардсан нөхцөлд аэродромын хяналтын үйлчилгээ зэргийг хангах үүрэгтэй. Гэрчилгээжсэн эсэхээс үл хамааран аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн аэродром дээр ашиглаж байгаа төхөөрөмжид тавих хяналттай байвал зохино.

Тиймээс аэродром дээр UNICOM, эсхүл AWIB үйлчилгээний үйл ажиллагааг аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрлөөр явуулахыг дүрмээр шаарддаг. Энэ зөвшөөрлийг үйл ажиллагаа эрхлэгчийн холбогдох баримт бичгийн хуулбарын хамт бичгээр олгоно. Энэ Үл ажиллагааг тогтмол хянаж байх шаардлагатай.

AWIB болон UNICOM үйлчилгээний шаардлага.**АМС 139.353 (b)(1 болон 2)-Үйл ажиллагааны шаардлага**

Үйлчилгээ үзүүлэгч/үйл ажиллагаа эрхлэгч тухайн үйлчилгээг эхлэхээс өмнө дуудлагын нэр болон радио зөвшөөрлийг авсан байх ёстой. Үүнд 139.353 (а)(1) болон 139.353 (а)(2)-ыг ашиглана.

АМС 139.353 (b)(3) - ICAO системийн шаардлагын хэрэгжилт

UNICOM үйлчилгээнд ашигладаг радио төхөөрөмж нь давтамжийн хүлцэх алдаа болон ICAO Annex 10-ийн шаардлагагүй тархалтын холбогдох шаардлагыг хангасан байна. Даргын гаргасан шаардлагад нийцэх радио төхөөрөмжийн холбогдох дүрмийн техникийн шаардлагыг хангах нэг арга бол төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн тодорхойлолтын мэдээллийг хадгалах юм. Энэ мэдээллийг, нисэхийн холбооны шаардлагыг тухайн төхөөрөмж хангаж байгаа эсэхийг тодорхойлоход хэрэглэдэг. Эдгээр мэдээлэл байхгүй тохиолдолд техникийн тодорхойлолтыг шалгах нарийвчилсан мэдээллийг хадгалсан байна. Дүрэмд тусгасан шаардлага нь зөвхөн

UNICOM болон AWIB үйлчилгээний радио системийн хангалтын хүсэлтийг гаргахад зориулагдсан.

АМС 139.353 (b)(4) - ICAO холбооны журмын хэрэгжилт

Зохих холбооны үйл ажиллагааны журамд нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний хэт өндөр давтамжтай /VHF/ радио-холбоо болон нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний дамжуулалт зэрэгт хамаарах ерөнхий болон тусгай журам байдаг. Эдгээрийг Annex 10, Vol II, Chapter 5, Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ - Дуут холбоо болон Chapter 7, Нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ зэрэг баримт бичигт дэлгэрэнгүй заасан болно. Индексийн тайлбарыг Хавсралт А-д үзүүлэв.

Дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх нэг арга бол үйл ажиллагаа эрхлэгчийн үнэлгээ болон үндсэн сургалтанд хэрэглэгдэх шаардлагатай журмыг хамруулах үйл ажиллагаа юм. Мөн 139.355 заалтын зөвлөмжийн мэдээллийг анхаарах шаардлагатай.

Үйл ажиллагаа эрхлэгч нь нисэхийн холбооны үйл ажиллагааны тогтсон хэв журмыг ажиглаж байх үүрэгтэй.

GM 139.353 (c)(1) - Алдаатай, эсхүл төөрөгдүүлэх дамжуулалт

Алдаатай, эсхүл төөрөгдүүлэх мэдээллийг дамжуулахгүй байх асуудал нь хоёр хэсгээс бүрдсэн байх шаардлагатай. Нэг - автоматжуулсан, эсхүл гараар шалгах ажиллагааны үеийн дамжуулалт ялангуяа хэрэв мэдээлэл үүссэн үедээ тухайн үеийн нөхцөлийг үзүүлэхгүй байх магадлалтай өгөгдлийн хүрээг агуулсан бол үйлчилгээг зогсоох ёстой. Хоёр - автоматжуулсан нэвтрүүлэх системтэй үед, нэвтрүүлэг зогсоосон, эсхүл шинэчилсэн үед холбогдох нөхцөлд өөрчлөгдсөн тохиолдолд баталгаажуулах шалгалт хийх ёстой.

Алдаатай мэдээлэл дамжуулах ажиллагааг зогсоох нь нисгэгчийг буруу мэдээлэлд итгэхээс зайлсхийх аюулгүй байдлын чухал арга юм.

АМС 139.353 (c)(2) - Үргэлжлүүлэн дамжуулах

Дүрмийн энэ дэд хэсэг нь үйл ажиллагаа эрхлэгч/үйлчилгээ үзүүлэгчийн хүлээн авсан, дамжуулсан мэдээлэл нь өөрчлөлтгүй болохыг баталгаажуулах тогтолцоотой байхыг шаарддаг. Энэ шаардлагыг биелүүлэхийн тулд, ялангуяа агаарын хөлөгт байршлын, эсхүл нислэг дагах хяналтын үйлчилгээний мэдээллийг дамжуулах үед үйл ажиллагаа эрхлэгч нь нарийвчилсан мэдээллийг бичих болон яаралтай авах арга хэмжээний карт/шалгах хуудасны тогтолцоотой байх шаардлагатай. Хатуу хавтас, бичгийн хавчуурга, эсхүл өөрөө наалдагч тууз бүхий хавтас болон самбартай байх тогтолцоо нь шаардлагад нийцнэ.

GM 139.353 (c)(3) - Нислэгийн хөдөлгөөн, эсхүл цаг уурын үйлчилгээний зөрчил

Дүрмийн энэ дэд хэсэг нь маш тодорхой, тайлбарлах шаардлагагүй юм. UNICOM, эсхүл AWIB үйлчилгээний хангалт нь ямар нэгэн гэрчилгээжсэн нислэгийн хөдөлгөөний, эсхүл цаг уурын үйлчилгээтэй зөрчилдөх ёсгүй. UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ үзүүлж байгаа газарт, жишээ нь гэрчилгээжсэн үйлчилгээний үйл ажиллагааны хугацааг сунгахад үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн үзүүлж байгаа үйлчилгээ бүрд үзүүлэх зөвшөөрлийн баримт бичигтэй байвал зохино. Зөвшөөрлийн баримт бичиг нь ямар нэгэн зөрчил байхгүй болохыг баталгаажуулах ба үүнд

зөрчлийг шийдвэрлэх талаарх зөвшөөрлийн баримт бичиг агуулсан байна. Эдгээрийг тогтмол хянаж байх шаардлагатай.

UNICOM болон AWIB үйлчилгээний радионы хамрах хүрээ болон бусад радио холбооны тохируулагдсан үйлчилгээ үзүүлэгчтэй зөрчил үүсгэхгүй байхыг баталгаажуулах шалгалтыг хийсэн байна.

GM 139.353 (d)(1) - Алдаатай, эсхүл төөрөгдүүлэх дамжуулалтаас урьдчилан сэргийлэх

Дүрмийн энэ дэд хэсэг нь (c)(1)-д заасантай дүйцэх шалтгаан, эсхүл өөрчлөгддөг нөхцөл нь шинэчлэгдэж байгааг баталгаажуулах үр дүнтэй хамгаалалттай байхыг шаарддаг. Хэрэв UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ бүрэн автоматжуулагдсан бол ослоос сэргийлсэн хамгаалалттай байх, эсхүл тогтмол хянаж байх ажилтантай байж болно. Автоматжуулсан шалгах ажиллагааны үеийн дамжуулалт ялангуяа хэрэв мэдээлэл үүссэн үедээ тухайн үеийн нөхцөлийг үзүүлэхгүй байх магадлалтай өгөгдлийн хүрээг агуулсан бол автоматжуулсан систем нь үйлчилгээг зогсоох ёстой.

GM 139.353 (d)(2) - Алдаатай дамжуулалт гэж үзсэн үеийн үйлчилгээг цуцлах

Энэ дэд хэсэг нь үйлчилгээ үзүүлэгч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгч нь алдаатай мэдээлэл дамжуулсныг сэжиглэх шалтгаан байгаа бол дамжуулалтыг аль болох түргэн зогсоохыг маш тодорхой заасан. Алдаатай мэдээлэл дамжуулах нь аюулгүй байдлын асуудалд орно.

GM 139.353 (d)(3) - Цаг агаарын мэдээний минимум шаардлага

Энэ дэд хэсэг нь үйлчилгээ үзүүлэгч/үйл ажиллагаа эрхлэгч нь цаг агаарын ямар нэгэн мэдээг мэдээлэхэд тавих минимум стандартын шалгууртай байхыг баталгаажуулна. ИНД-174-д цаг агаарын үндсэн мэдээний хангалтын тодорхойлолт болон түүнд тавих шаардлагыг заасан. ИНД-174 болон холбогдох АС нь энэ АС-д хамааралтай тул энэ тодорхойлолт болон цаг агаарын үндсэн мэдээг мэдээлэхтэй холбоотой тайлбар материалыг судалсан байна.

UNICOM Үйлчилгээ

139.353 (e)(1)-139 353 (g) нь UNICOM үйлчилгээ үзүүлэгч/үйл ажиллагаа эрхлэгчид хамааралтай ба үзүүлж байгаа үйлчилгээ болон үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

GM 139.353 (e)(1)-(7) - UNICOM Үйлчилгээ

Эдгээр дэд хэсэгт UNICOM үйлчилгээ үзүүлэгч/үйл ажиллагаа эрхлэгчийн үзүүлэх үйлчилгээг маш ойлгомжтой бөгөөд тодорхой тайлбарласан. Дэд хэсэгтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг доор үзүүлэв.

Эдгээр дэд хэсгийн хамгийн чухал нь гэрчилгээжсэн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (Аэродромын хяналт, AFIS, ATIS) болон UNICOM үйлчилгээний үзүүлдэг гэрчилгээжээгүй мэдээлэл хоорондын заагийг тодорхойлдог болно.

ИН-ийн холбогдох Дүрэм нь ICAO-гийн зохих баримт бичиг болон гаргасан шаардлагаас үндэслэгдэн боловсруулагдсан.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний хувьд, ИНД-172 нь чухамдаа стандарт болон практик зөвлөмж (SARPS), Агаарын навигацийн үйлчилгээ (PANS), Annex 11, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ ба Doc 4444 агаарын болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, Annex 2, Олон улсын стандарт, Агаарын зайн дүрмийн журмын тусгал болон боловсруулагдсан.

ИНД-172-ийн дагуу гэрчилгээжүүлэхэд шаардах илүү нарийн шаардлагыг ICAO-гийн боловсруулсан Annex болон зөвлөмж материалд үндэслэн боловсруулсан. UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид тавьж байгаа харьцангуй хатуу шаардлага бус тул үзүүлж байгаа үйлчилгээнд хязгаарлалт тавих шаардлагатай. Энэ нь зааварчилгаа өгөгдсөн гэрчилгээ бүхий нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнээс жишээ авч хязгаарлалтыг тодорхойлох бөгөөд өгөгдсөн зөвлөмж болон мэдээллийн тайлбар нь мөн байдаг болно. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй үед нисгэгчийн үүрэг хариуцлага нь үйл ажиллагаа эрхлэгч рүү шилжих бөгөөд нисгэгч нь энэхүү заалтыг чөлөөлөгдсөнөөс бусад нөхцөлд дагаж мөрдөх үүрэгтэй.

Зорилгот нийцсэн гэрчилгээтэй ИНД-172-ын үйлчилгээ нь цогц зөвлөгөө болон мэдээллийн үйлчилгээг үзүүлдэг бол UNICOM болон AWIB үйлчилгээ нь нисгэгчид хэрэгтэй үндсэн мэдээллийг тайлбаргүйгээр өгдөг.

Үндсэн нөхцөл нь UNICOM үйлчилгээ ИНД-172-ийн дагуу гэрчилгээжээгүй бол ИНД-172, Бүлэг 1-д заасан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй адил ямар нэгэн үйлчилгээ үзүүлэхгүй болно.

GM 139.353 (e)(1) - Цаг агаарын мэдээ

Нисэхийн цаг агаарын мэдээг ИНД-174-д заасан. ИНД-174, AC174-1 хамаарах зөвлөмжийн баримт бичигт заасан шаардлага нь энэ AC-тай хамтруулан хэрэглэх үүднээс судлагдсан байвал зохино. Цаг агаарын үндсэн мэдээнд тавих шаардлагыг 174.6-д тайлбарласан ба холбогдох AC174-1-ийн тайлбарыг 174.1, 174.3 болон 174.6-д тодорхойлсон. UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь ихэнх тохиолдолд UNICOM үйлчилгээний хангалт хийгдэж байгаа аэродром дээр цаг агаарын үндсэн нөхцөлийн талаарх мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ. Цаг агаарын үндсэн мэдээний элемент нь цаг агаарын үндсэн мэдээгээр хангах үйлчилгээний шаардлагын дагуу 174.6-д тусгагдсан. Зарим тохиолдолд UNICOM үйлчилгээ нь ИНД-174 (эсхүл 174-ийн зарим хэсэгт)-ийн дагуу гэрчилгээжих ба аэродромд зориулж цаг уурын урьдчилсан мэдээ, цаг агаарын үндсэн мэдээ зэргээр хангах боломжтой байна.

ИНД-174-ийн дагуу цаг уурын мэдээллээр хангадаг UNICOM үйлчилгээний аливаа үйл ажиллагаа эрхлэгч нь гэрчилгээжилтэд зориулсан тогтолцоотой байна.

GM 139.353 (e)(2) - Ашиглахаар сонгосон хөөрч буух зурвас

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын хөлгийн нисгэгчийн тайлан болон холбогдох цаг уурын мэдээ, эсхүл цаг агаарын үндсэн мэдээнд харуулсан салхины чиглэлийн мэдээлэлд тулгуурлан ашиглахаар сонгосон ХБЗ-ны мэдээллээр аэродром дээр байгаа нисгэгч болон бусад хүмүүсийг хангана. Холбогдох цаг уурын мэдээлэл, сургалт, үйл ажиллагааны давтамжийг ажиглах ажиллагааг тухайн үйлчилгээний хангалт үзүүлэхээс өмнө хийх шаардлагатай.

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн үйл ажиллагаанд ашиглах ХБЗ-ыг тогтоох ёсгүй. Шийдвэр гаргах эрх нь тухайн төлөвлөж байгаа агаарын хөлгийн нисгэгчид байна.

АМС 139.353 (е)(3) - Нислэг дагах хяналтын үйлчилгээ

Нислэг дагах хяналтын үйлчилгээний хангалт нь ИНД-119 болон 135-ийн дагуу нислэг дагах хяналтын үйлчилгээний хангалтыг хэрэгжүүлэх үүднээс агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хамруулахыг зорьсон. Ингэснээр хэрэв агаарын хөлөг төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч байгаа бол холбогдох онцгой нөхцөлийн идэвхижүүлэх арга хэмжээ авагддаг. Агаарын тээвэрлэгчид тавих шаардлагыг 119.73, 119.121, 135.57 болон холбогдох АС119.3, АС119.1-д заасан байдаг. Ямар нэгэн нислэг дагах хяналтын үйлчилгээг төлөвлөж байгаа үед энэхүү АС-г мөн хамтатган хэрэглэнэ.

ИНД-119, агаарын тээвэрлэгч нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаар баталгаажуулсан нислэгийн төлөвлөгөөгүй аливаа нислэг дагах хяналтын үйлчилгээтэй байх ёстой. 119.73 болон 119.21 нь өөрийн нислэг дагах хяналтын үйлчилгээ бүхий ямар ч агаарын тээвэрлэгчид тавигдах шаардлагыг нарийвчлан тайлбарласан. Ихэнх тохиолдолд агаарын тээвэрлэгч нь өөрийн нислэг дагах хяналтын үйлчилгээтэй байхыг хүсдэггүй боловч нислэг дагах хяналтын үйлчилгээг авахын тулд UNICOM үйлчилгээ эрхлэгчтэй гэрээ байгуулдаг. Энэ арга нь хэдийгээр боломжтой боловч 119.73 болон 119.121-ийн шаардлагын дагуу агаарын тээвэрлэгч нь нислэг дагах хяналтын үйлчилгээтэй эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Хэрэв агаарын тээвэрлэгч нислэг дагах хяналтын үйлчилгээнд UNICOM үйлчилгээг ашигладаг бол ИНД-119-ийн агаарын тээвэрлэгч, дүрмийн дагуу ИНЕГ-аас UNICOM үйлчилгээнд холбогдох аудитын шалгалт хийгдэх шаардлагатай.

Энэ үйлчилгээг ашиглаж байгаа агаарын тээвэрлэгчид (119.73, 119.121, 135.91) UNICOM үйлчилгээ нь тухайн агаарын тээвэрлэгчийн хэрэгцээнд нийцсэн байх ёстой гэрчилгээжүүлэлтийн шаардлагатай байх ёстой. Эдгээр шаардлага нь Q карт, шалгах хуудас, зориулалтын хяналтын дэлгэц, эсхүл түүнтэй төсөөтэй хяналтын системийг багтаасан нислэг дагах хяналтын үйлчилгээнд зориулсан баримтжуулалтын тогтолцоогоор хангагдах боломжтой.

АМС 139.353 (е)(4) - Онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг эхлүүлэх

Нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэхтэй адил энэ үйлчилгээ нь нислэг дагах хяналтын үйлчилгээний салшгүй хэсэг, эсхүл дангаараа байж болдог. Аль ч тохиолдолд ашигласан системийг баримтжуулсан байх ёстой ба Q карт, шалгах хуудас, зориулалтын хяналтын дэлгэц, эсхүл түүнтэй төсөөтэй хяналтын системийг багтаасан байна.

GM 139.353 (е)(5) - Аэродромын давтамжид хариулах нэгж /AFRU/

Аэродромын давтамжийг хариулах нэгж нь ерөнхийдөө мэдээллийн дамжуулалт модуляцлагдсан болон дамжуулагдсан гэдгийг нисгэгчид баталгаажуулах үед хэрэгтэй. AFRU нь энгийн дуут дохионоос эхлээд бүрэн автоматжуулсан систем хүртэл байж болох бөгөөд аэродромын ачааллаас шалтгаалан харилцан адилгүй хувилбараар өгсөн дамжуулалтыг нарийвчлан давтах боломжийг олгодог. AFRU-ийн хангалт үзүүлдэг ерөнхий үзүүлэлтийг Хавсралт С-д үзүүлсэн.

GM 139.353 (е)(6) - Агаарын хөлгийн байрлалын талаарх мэдээлэл хүсэх

Энэ дэд хэсэгт UNICOM үйлчилгээний үйл ажиллагааны чухал хязгаарлалтын нэг багтдаг бөгөөд агаарын хөлгийн ерөнхий байршлын талаарх мэдээллийг дамжуулдаг.

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн мэдэж байгаа агаарын хөлгийн хаана байрлах талаар ямар нэгэн тайлбар хийх ёсгүй бөгөөд тайлбарыг дамжуулах нь үндсэн зарчимтай байна. Мөн агаарын хөлгийг танихыг оролдох, эсхүл ажиглагдсан агаарын хөлгийг агаарын хөлгийн мэдээлэлтэй харьцуулах ёсгүй. Энэ нь нислэгийн хөдөлгөөний мэдээлэл бөгөөд нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангах ажилтан нь ИНД-172-ийн дагуу гэрчилгээжсэн байх үүрэгтэй.

Нисгэгчийн хүсэлтээр үйл ажиллагаа эрхлэгч нь мэдэгдэж байгаа агаарын хөлгийн байрлалын талаарх мэдээллийг зөвхөн дамжуулна. Дамжуулж байгаа мэдээлэл нь үйл ажиллагаа эрхлэгчээс хийсэн үнэлгээ, эсхүл тайлбарыг оруулаагүй байх ёстой. Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл гэж, эсхүл хангалт үзүүлсэн нийт хөдөлгөөний аль алинийг зааварчлах ёсгүй.

Энэ дүрмийн дагуу хүлээн зөвшөөрөхүйц болон хүлээн зөвшөөрөхүйц бус зүйлсийн жишээг дор харуулав.

Хэрэв нисгэгч ХҮ аэродромын зүүн өмнөд хэсгийн нислэгийн хөдөлгөөний талаар мэдээлэл авахыг хүсвэл хариу нь нислэгийн хөдөлгөөний мэдээлэл биш бөгөөд мэдэгдэж байгаа агаарын хөлгийг заах.

Хүлээн зөвшөөрөхүйц

... мэдээлэгдсэн хөдөлгөөн нь 1105 чиглэд байгаа Bravo Lima Tango өмнөдийн 10 nm-д 1500 ft-д нийлж байна

... хойд чиглэд нам өндөрт ойролцоогоор 3 nm-д жижиг агаарын хөлөг ажиглагдсан.

... зүүн чиглэд 8 nm-д нам өндөрт өвс таригч төхөөрөмж ажиллаж байгаа гэж мэдээлэгдсэн.

Хэрэв нисгэгч ХҮ аэродромын зүүн өмнөд хэсгийн нислэгийн хөдөлгөөний талаар мэдээлэл авахыг хүсвэл хариу нь ямар хөдөлгөөн хийгдсэн нь нислэгийн хөдөлгөөний мэдээлэл биш бөгөөд мэдэгдэж байгаа агаарын хөлгийг заах.

Хүлээн зөвшөөрөхүйц бус

.... 1500 ft-д өмнөдийн 10 nm-д Bravo Lima Tango ажиглагдсан.

....1000 ft-д хойд 3 nm-д Foxtrot Hotel Oscar ажиглагдсан.

.... Нийт тойрог хөдөлгөөн нь

.... Бүх тойрог хөдөлгөөн нь.

Тэмдэглэл:- UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид ирсэн хүсэлтээр тэд нарт мэдэгдэж байгаа агаарын хөлгийн ерөнхий байршлын талаарх мэдээллийг мэдээлдэг. Тэд дээрх мэдээллийг тайлбарлах ёсгүй. АМС 139.353 (c)(2)-ын тайлбарыг үзнэ үү.

GM 139.353 (e)(7) - Аэродромын мэдээлэл

Энэ дэд хэсгийн зорилго нь үйл ажиллагаа эрхлэгчээс нисгэгч, эсхүл ХБЗ-ны ойр орчимд ажиллаж байгаа ажилтныг нисэхэд учрах гэнэтийн аюулын талаарх мэдээллээр хангахыг зөвшөөрөхөд оршино.

Энэ нь онцгой нөхцөлийн нөхцөл байдалд зориулж дүрэмчлэгдээгүй болно. Энэхүү нөхцөлд ухаалгаар хандах ёстой.

Аэродромын мэдээлэлд аливаа нислэгийн хөдөлгөөний мэдээлэл багтах ёсгүй.

Аюулын мэдээлэл нь аэродром дээр явагдаж байгаа ажил, эсхүл хөдөлгөөний бус бүсэд байгаа аэродромын хэрэглэгчид тохиолдож болох аюулын талаарх мэдээлэл байна.

Аюулын талаарх мэдээллийн хангалт нь мэдээллийн эх үүсвэр баталгаатай байхыг шаарддаг ба үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромын хүрээлэн байгаа орчны талаар холбогдох сургалт/мэдлэг-тэй байна. Аюулын талаар ирүүлсэн мэдээлэл болон эх үүсвэрийн талаар тэмдэглэл хийдэг байна.

GM 139.353 (f)-UNICOM хязгаарлалт

Энэ Дэд хэсэг нь маш тодорхой болно. Гэрчилгээжсэн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнээс доогуур төвшинд хязгаарлаж байгаа UNICOM болон AWIB үйлчилгээний хангалтын талаар дурьдсан F Бүлгийг илүү тодорхой болгох асуудлыг багтаасан.

Хэрэв аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэхийг хүсвэл үйлчилгээ үзүүлэгч нь ИНД-172-ын дагуу гэрчилгээжих үүрэгтэй.

AMC 139.353 (g)- UNICOM ажилтанд тавих шаардлага

Энэ дэд хэсгийн зорилго нь үйл ажиллагаа эрхлэгч нь өрсөлдөх чадвартай, үйлчилгээ үзүүлэгчээр сонгогдох боломжтой эсэхийг баталгаажуулах үнэлгээ өгөх болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг үйлчилгээ үзүүлэгчид өгнө. Энэ нь үйлчилгээ үзүүлэгчид мөн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах эрхийн түвшинг мэдээлэх үүргийг хариуцуулдаг.

Үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагатай сургалтын түвшин нь тооцоологдож байгаа хөдөлгөөний нягтаршил болон UNICOM үйлчилгээний хангалтын түвшнээс шалтгаална.

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг өгөх сургалтыг шаарддаг:

Энэ Дүрмээр зөвшөөрөх мэдээлэлд дүрмийн шаардлагаар тавих хязгаарлалтын талаарх дэлгэрэнгүй мэдлэг бүхий иргэний нисэхийн орчинд ажиллах анхан шатны мэдлэг,

- (a) хүрээлэн байгаа орчны талаарх мэдлэг,
- (b) аэродромын талаарх мэдлэг,
- (c) радио-холбооны үйл ажиллагааны журмын талаарх чадвар,
- (d) цаг агаарын үндсэн ажиглалтын үр чадвар,
- (e) бусад шаардлагатай авах арга хэмжээний талаарх зохих мэдлэг гэх мэт.

Хийх шаардлагатай сургалтын хамгийн бага түвшин нь Хавсралт В-д заасны дагуу үзүүлж байгаа үйлчилгээний түвшний шаардлагад нийцсэн байна.

UNICOM үйлчилгээ үзүүлэгч нь UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч зохих сургалтанд хамрагдаж, үнэлэгдсэн болон эрх олгогдсон эсэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Сургалтын үйл ажиллагаа нь зохих үнэлгээ болон үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөл бүхий системтэйгээр хэрэгжигдэх ёстой. Үнэлгээ болон эрх олголт нь бүртгэгдэж, нэгжийн бүртгэлд хадгалагдана.

Ажилтанд үнэлгээний үр дүн болон эрх олголтын талаарх мэдээллийг бичгээр мэдээлнэ.

AWIB үйлчилгээ

139.353 (h)(1)-(7) нь AWIB үйлчилгээгээр хангаж/үзүүлж байгаа этгээдэп хамаарах бөгөөд үйлчилгээний хангалт болон хангалтын нөхцөлийг үзүүлсэн болно. Холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг дор үзүүлэв.

GM 139.353 (h)(1)-(5)- Цаг агаарын үндсэн мэдээ

Эдгээр дэд хэсэг нь цаг агаарын үндсэн мэдээтэй ижил AWIB үйлчилгээгээр хангадаг цаг агаарын мэдээллийг жагсаан харуулдаг.

Дамжуулах мэдээллийг автомат мэдрэгч, бодит ажиглалт, эсхүл эдгээрийн хосолмол байдлаар авдаг бөгөөд байршлын хувьд өөр өөр байх талтай.

Дамжуулсан цаг агаарын мэдээллийг 174.6-д заасан цаг агаарын үндсэн мэдээг мэдээлэх стандартын дагуу хангана.

ИНД-174-ийн шаардлага нь зөвлөмжийн материал болох AC174.1-тэй холбогдох бөгөөд энэ AC-тай хамтатган хэрэглэнэ. Үүнд ажиглалт хийхэд ашигладаг төхөөрөмжид тавих шаардлага болон тухайн төхөөрөмж дээр хийгдэх шалгалт, ажилтны сургалтыг агуулсан. AC174-1-ийн 174.1, 174.3 болон 174.6-д тодорхой тусгасан байдаг.

GM 139.353 (h)(6)- Ашиглахаар сонгосон хөөрч бүүх зурвас

Энэ дэд хэсэг нь AWIB үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчийг тэдгээрийн мэдээлэлд ашиглахаар сонгосон ХБЗ-ны мэдээллийг оруулахыг зөвшөөрдөг. Ашиглахаар сонгосон ХБЗ-ны талаарх мэдээлэл нь тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын хөлгийн нисгэгчийн тайлан болон холбогдох цаг уурын мэдээ, эсхүл цаг агаарын үндсэн мэдээг харуулсан ХБЗ-ны мэдээлэл байна.

Туайн үйлчилгээг үзүүлэхээс өмнө цаг агаарын үндсэн мэдээний холбогдох шаардлага, үйл ажиллагааны давтамжийн тасралтгүй ажиглалт, эсхүл автоматжуулсан систем шаардлагатай байдаг. Автоматжуулсан систем ашиглаж байгаа үйл ажиллагаа эрхлэгч ИНД-174-ийн цаг агаарын үндсэн мэдээнд тавих шаардлагыг хангах ёстой. AWIB үйл ажиллагаа эрхлэгч нь аль ХБЗ ашиглахыг тодорхойлох нь дүрмийн дагуу үл зөвшөөрөгддөг. Нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн нисгэгч энэхүү шийдвэрийг гаргана.

GM 139.353 (h) (7)-Аэродромын мэдээлэл

Энэ мэдээлэл нь агаарын хөлгийн үйл ажиллагаа, эсхүл агаарын хөлгийн нисгэгчид хамаарах мэдээллийг агуулдаг. Ямар нэгэн дүрэмд заасны дагуу гэрчилгээжүүлэлтийн давуу эрхээр мэдээлсэн аливаа мэдээллийг багтаагаагүй байх шаардлагатай.

Мэдээллийн төрлийн талаарх жишээ:

Гадаргуун мэдээлэгдсэн нөхцөл.

Зүлгэн заагч хаагдсан.

Нисгэгч нарны гялбаанд өртөх магадлалтай гэж үзэх.

Аэродром дээр хийгдэж байгаа ажил үргэлжилж байгаа болно.

UNICOM үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

GM 139.355 (a)- UNICOM үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

Энэ дэд хэсэг нь UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид хамааралтай бөгөөд UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлагыг үзүүлдэг. Үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь дээрх бүх шаардлагыг хангасан гэдгийг үзүүлэх боломжтой байна.

AMC 139.355 (a)(1)- Холбооны журам.

Энэ дэд хэсэг нь UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид хамаарах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөртэй гэдгийг баталгаажуулахыг заасан.

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа нь Монгол Улсын иргэний нисэхийн тогтолцоонд байдаг үйлчилгээний хэвшмэл үйл ажиллагаа бөгөөд энд заасны дагуу хэрэгжүүлсэн байх шаардлагатай.

Зөвхөн үйлчилгээний хангалтанд шаардлагатай, эсхүл аюулгүй ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх мэдээллийг дамжуулах үед баримтлах дэг журам нь хянагдах шаардлагатай. Нисгэгчийн хүлээн авч байгаа холбооны бүх журам ижил стандартын байх шаардлагатай ба эдгээр нь Annex 10, Vol II-т заасан хэрэглэгдэх журмаас үндэслэн боловсруулагдсан байна.

Эдгээр нь нислэгийн радио холбооны үйлчилгээ үзүүлэгчийн сургалтанд шаардлагатай баримтлах дэг журмыг баталгаажуулснаар хэрэгждэг.

Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ АС-ын Хавсралт D-д заасан шаардлагын дагуу хангалттай, эсхүл тэнцсэн гэж үнэлэгдсэн гэдгийг үзүүлэх боломжтой байх ёстой. Энэ сургалт болон үнэлгээний тэмдэглэл нь хадгалагдана.

AMC 139.355 (a)(2) - Санал болгосон үйлчилгээний шаардлагыг хангах сургалт

Энэ дэд хэсэг нь үйлчилгээ үзүүлэгч/үйл ажиллагаа эрхлэгчид хамааралтай бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээрийн үүрэгт ажлыг хэрэгжүүлэхэд зохих сургалтын хөтөлбөртэй эсэхийг баталгаажуулах талаар мөн дурьдсан болно. UNICOM үйлчилгээний хангалтанд нисэхийн салбарт аэродромын үйл ажиллагааны талаар зохих ажлын мэдлэгтэй байх шаардлагатай.

Энэ мэдлэг нь нислэгийн журам, аэродром дээр болон түүнтэй ойролцоо газар хийгдэж байгаа үйл ажиллагаатай холбоотой нисэхийн салбарт хэрэглэдэг үг хэллэг болон нислэгийн зааварчилгааны нэгж, аэродром дээр байгаа тээврийн хэрэгслийн үйл ажиллагаа, аэродром дээрх аюулгүй аюулгүй байдал, онцгой нөхцөлийн үйлчилгээ болон үзүүлж байгаа үйлчилгээнд тохирсон холбогдох мэдээллийг анхааруулах ажлыг эхлүүлэх.

Үйл ажиллагаа эрхлэгч нь сургалтанд хамрагдсан болон тохиромжтой сэдвийн дагуу хангалттай гэж үнэлэгдсэн болохыг харуулах тэмдэглэлийг үзэх боломжтой байна. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь 119.73, 119.121, 135.91-ийн дагуу үйлчилгээ нь агаарын тээвэрлэгчийн шаардлагад нийцсэн

үед нислэг дагах хяналтын үйлчилгээ санал болгосон үед тавигдах тусгай шаардлага байна. Үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээрийн хангаж байгаа мэдээлэлд дүрмийн хязгаарлалт байдаг талаар сайтар мэдлэгтэй байх ёстой.

Энэ нь үйл ажиллагаа эрхлэгч дүрэм, журам бүрийн талаар мэдлэгтэй байх гэсэн үг биш бөгөөд хэрэв тэдгээр нь шаардлагатай мэдлэггүй бол дүрэм, журмын шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулах өөрийн дотоод үйл ажиллагааны талаар сайтар мэдлэгтэй байх ёстой.

Хавсралт В-д холбогдох сэдвийн жагсаалтыг үзүүлсэн - энэхүү жагсаалтыг үйлчилгээ үзүүлэгчид шаардлагатай өргөн хүрээг хамарсан болон сургалтын гэж үзэж болохгүй.

АМС 139.355 (а)(3) - Эрхийн хүрээний баталгаа

Энэ дэд хэсэг нь үйлчилгээ үзүүлэгчид хамаарах бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нь эрхийн хүрээг мэддэг байхыг баталгаажуулахыг мөн заасан.

Үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээрийн эрхийн хүрээг харуулсан гэрчилгээгээр хангагдах бөгөөд хугацаа нь дараагийн үнэлгээ хийгдэх хүртэл хүчинтэй байна. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр эрхийн тэмдэглэлийг хадгална.

Үйлчилгээний мэдээлэл

GM 139.357-AIS мэдээллийн үйлчилгээ

Энэ Дүрэм нь UNICOM болон AWIB үйлчилгээ үзүүлэгчид хамаарах бөгөөд хангагдаж байгаа мэдээлэл нарийвчлалтай болон зарлагдахад шаардлагатай хугацаа байгаа эсэхийг баталгаажуулах зорилготой. Энэ нь AWIB болон UNICOM үйлчилгээний мэдээлэлд нийцсэн байх шаардлагыг дэлгэрэнгүй талбарлах болон AWIB, UNICOM үйлчилгээний ерөнхий болон тусгайлсан шаардлагыг агуулсан болно.

AIS-ын эмхэтгэлд зарлах шаардлагатай мэдээлэл нь зарлахаас өмнө өөрчлөлтийг хийхийг тооцсон 90 хоногийн хугацаатайгаар хангагдана.

UNICOM, эсхүл AWIB үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь хамгийн багадаа 90 хоногийн өмнө AIS-ын эмхэтгэлийн холбогдох ажилтантай холбогдож хангах мэдээллийн дэлгэрэнгүй болон маягтийн талаар тохиролцоно.

AIS-ын эмхэтгэл /AIP/ үйлчилгээ үзүүлэгчид зориулсан мэдээллийн товхимол болон зориулалтын бөглөх маягттай байна. Эдгээр нь AIP-аас болон AIS-ын цахим хуудаснаас авах боломжтой байна. https://ais.mn/index.php?option=com_content&view мэдээлэл https://ais.mn/images/Files/reference_book/listOfValidNotam/List мэдээллийн товхимолын PDF хувилбар.

AIS -тай холбоо барих хаяг

Mail: P.O.Box 59

Address: Khan-Uul district, "Chinggis Khaan" international Airport

Ulaanbaatar 17120, Mongolia

Tel: 976-11-283131, 976-11-283126

Fax: 976-70049838

GM 139.357 (a)(1) - Станцын тодорхойлолт

Дэд хэсэг 1 - тайлбар шаардлагагүй.

GM 139.357 (a)(2) - Аэродромын тодорхойлолт

Дэд хэсэг 2 - тайлбар шаардлагагүй.

GM 139.357 (a)(3) - Үйлчилгээний цаг

Дэд хэсэг 3 - тайлбар шаардлагагүй.

GM 139.357 (a)(4) - Үйлчилгээний хангалт

Дэд хэсэг 4 нь үйлчилгээ үзүүлэгчийг AIP дэх хүснэгтэн мэдээлэл болон аэродромын хуудсанд шаардлагатай мэдээллээр хангахыг шаарддаг.

GM 139.357 (a)(5) - Үйл ажиллагааны бусад холбогдох мэдээлэл

Дэд хэсэг 5 нь үйлчилгээ үзүүлэгчийг хүснэгтэн мэдээлэл болон аэродромын хуудсанд үйл ажиллагааны бусад холбогдох шаардлагатай мэдээллээр хангахыг шаарддаг.

GM 139.357 (a)(6) - Захиргааны мэдээлэл

Дэд хэсэг 6 нь үйлчилгээ үзүүлэгчийг албан ёсны үйлчилгээ үзүүлэгч болон зарлагдсан мэдээлэл нь зөв эсэхийг шалгах, баталгаажуулах техникийн мэдлэгтэй, NOTAM мэдээнд шаардлагатай шалгалт хийх, санаачлагатай, зохих мэдлэг бүхий ажилтан хоёрын дэлгэрэнгүй мэдээллийг явуулахыг шаарддаг. Энэ нь нэг хүн байж болох талтай. НМЭ үйлчилгээ үзүүлэгч нь нотолгоо болгох зорилгоор ажилтны гарын үсгийг шаардана.

Шилжилтийн зохицуулалт

GM 139.359- Шилжилтийн зохицуулалт

Энэ дэд хэсэгт тайлбар шаардлагагүй.

Хавсралт А

Аппех 10 Vol II-ын Холбогдох хэсгийн гарчиг

Заалтын дугаар нь Аппех 10 Vol II Chapter 5-7-гийн дугаарыг илэрхийлнэ.

Бүлэг 5. Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ

5.1 Ерөнхий зүйл

- Мэдээллийн төрөл
- Мэдээллийг цуцлах

5.2 Радио-холбооны журам

5.2.1 Ерөнхий зүйл

- Хэрэглэгдэх хэл
- Радио-холбооны үгийг үсэглэх
- Радио-холбооны дамжуулалтын дугаар
- Дамжуулах техник
- Мэдээллийн бүтэц
- Дуудлага
- Шалгалтын журам
- Холбооны төв

5.2.2 Холбоог шинээр үүсгэх болон баталгаажуулах

- Холбоог ажиглах/Үйлчилгээний цаг
- VHF холбооны шилжүүлэлт
- Холбоо алдагдах

5.3 Яаралтай болон ослын радиохолбооны журам

5.3.1 Ерөнхий зүйл

5.3.2 Ослын радио-холбоо

- Ослын үеийн агаарын хөлгийн авах арга хэмжээ
- Ослын мэдээллийг авсан эхний станц эсхүл тухайн станцад хаягласан мэдээлэх арга хэмжээ
- Чимээгүй байх шаардлага
- Бусад бүх станцын авах арга хэмжээ
- Чимээгүй байх болон ослын холбоог зогсоох

5.3.3 Яаралтай үеийн радио-холбоо

- 5.3.3.4-д зааснаас бусад агаарын хөлгийн яаралтай нөхцөлийн мэдээлэл
- Ослын мэдээллийг авсан эхний станц, эсхүл тухайн станцад хаягласан мэдээлэх арга хэмжээ - Бусад бүх станцын авах арга хэмжээ
- Эмнэлгийн тээвэрлэлтэд ашиглах агаарын хөлгийн авах арга хэмжээ
- Бусад эмнэлгийн тээвэрлэлтийн мэдээллийг хүлээн авах станц, эсхүл хаягласан станцын авах арга хэмжээ

5.4 Хууль бус үйлдэл хийхтэй холбоотой харилцаа холбоо

Бүлэг 7. Нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ**7.1 Ерөнхий зүйл****7.1.1 Дамжуулах материал****7.1.2 Хуваарь болон давтамж****7.1.3 Үйлчилгээний тасалдал****7.2 Радио-холбоо дамжуулах журам****7.2.1 Дамжуулах техник****7.2.2 Ерөнхий дуудлагын өмнөх үг**

Хавсралт В

UNICOM Үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчийн сургалт

Дараах зүйл нь 139.353 (г)-ийн шаардлагыг хангахад зориулсан сургалтын төрлийн тойм болно. Сэдэв болон сургалтын түвшин нь үзүүлж байгаа үйлчилгээний түвшинд хүрэх хэмжээний байх шаардлагатай.

UNICOM Үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч - Сургалтын хөтөлбөр

(a) Суралцагч

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид зориулсан 2 ангиллын сургалт байхаар тооцогдсон байдаг.

1. Сүүлийн 10 жилийн турш нислэгийн удирдлагын үйлчилгээ, эсхүл арилжааны нисгэгчийн лиценз эзэмшдэг хүмүүс
2. Дээрх суурь мэргэжлийн аль нь ч байхгүй хүмүүс

(b) Сургалтын хугацаа

1-р ангилалд багтсан хүмүүст ажлын 10 өдрөөс багагүй хугацаагаар. Бусад бүх суралцагч ажлын 40 өдрөөс доошгүй хугацаагаар.

(c) Сургалтын төлөвлөгөө

Сургалтын хөтөлбөр нь онолын болон дадлагын сургалтын хосолсон хэлбэр бүхий баримтжуулсан төлөвлөгөө байх шаардлагатай. Хамрагдах шаардлагатай сургалтын сэдвийн жишээг дор үзүүлэв.

Суралцагч сургалтын төлөвлөгөөний бүх хэсэгт тэдгээрийн мэдлэг, үр чадварыг харуулах ба холбогдох тэмдэглэл нь хадгалагдана.

(d) Үр чадварын зөвлөгөө

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээрийн үр чадварыг баталгаажуулах бичгэн баталгааг авсан байх болон дараагийн үнэлгээгүйгээр аль чадвар нь хүчинтэй байхаар тооцогдох хугацааг заасан байна. Үйл ажиллагаа эрхлэгч нь үр чадварыг баталгаажуулах бичгэн баталгааг гаргах шаардлагуудыг баримтжуулсан байвал зохино. Энэ нь гэрчилгээжүүлэх хэлбэрээр хийгдэж болно. UNICOM үйлчилгээг явуулах үр чадвартай гэдэг нь тогтоогдсон ажилтныг харуулах тэмдэглэл нь хадгалагдана.

(e) Хүчинтэй байх хугацаа болон Үргэлжлэх үр чадвар

UNICOM үйлчилгээ үзүүлэгч нь үргэлжилсэн үр чадварын үнэлгээний шаарлагуудыг болон ямар тохиолдолд үр чадварын баталгаа нь хасагдах ёстойг баримтжуулсан байна. Үр чадварын үнэлгээ нь 65.357 болон 65.359-д нислэгийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид тавигддаг шаардлагатай ижил байна. Үр чадварыг баталгааг хасах шалтгааны жишээ нь эрүүл мэнд, сахилга батын зөрчил, үр чадвар дутуу зэрэг байна.

Unicom үйлчилгээний сургалтын модуль

- (a) Үзүүлж байгаа үйлчилгээний түвшин өөр өөр байдгаас шалтгаалж UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь үзүүлж байгаа үйлчилгээнд шаардлагатай

UNICOM үйлчилгээний үйл ажиллагааг явуулж байгаа ажилтанд зориулсан сургалтыг боловсруулах хэрэгцээ гардаг. Гэрчилгээжсэн үйлчилгээ үзүүлэгчид тэдгээрийн гэрчилгээжүүлэлтийн дагуу сургалтын шаардлага тавигдана. Нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь нислэг дагах хяналтын үйлчилгээ үзүүлж байгаа гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн аудитын шаардлагад хамрагдана.

- (b) Цаг уурын мэдээллийн бүсэд, хамрагдах хүрээ нь хэрэгжүүлж байгаа цаг уурын ажиглалтын түвшин/гэрчилгээжүүлэлтээс хамаарна.
- (c) Дараах сургалтын хөтөлбөр нь шаардлагатай сургалтын нэг төрөл юм. Сургалтын түвшин болон хөтөлбөр нь үзүүлж байгаа үйлчилгээний түвшин болон үйлчилгээнээс хамаарч өөр өөр байна. Энэ нь ялангуяа цаг уур, нислэг дагах хяналт, онцгой нөхцөлийн идэвхижүүлэх арга хэмжээ болон үзүүлж байгаа үйлчилгээний үзлэг зэрэгтэй холбоотой.

Сургалтын модулийн сэдвийн задаргаа

Түвшин Нэг - Аэродромтой танилцах

Түвшин нэг болон хоёрт суралцагч нь холбогдох гарын авлага, эсхүл баримт бичгээс мэдээллийг байршуулах чадварын талаар аман шалгалтанд хамрагдсан байх болон өөрийн мэдлэгийн талаар практик шалгалт авагдсан байна.

Аэродромын байршил - Аэродромын танилцах аялалд оролцох

Орон нутгийн үйл ажиллагаа эрхлэгчид - Тэдгээр нь хэн болох, юу хийдэг эсэх

Хамгаалагдсан бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох - Тээврийн хэрэгслийг барих журмыг танилцуулах

UNICOM үйлчилгээ оффисийн байршлын зураг - Хаана байдаг, дотор нь юу байдаг эсэх

Түвшин Хоёр - Баримт бичиг болон Хамтын гэрээ

Аэродромын Ерөнхий заавар - Ажлын суурь мэдлэг

Аэродромын заавар - Ажлын суурь мэдлэг

Аэродромын аюулгүй байдлын заавар - Ажлын суурь мэдлэг

UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа - Бүх талын мэдлэг

Онцгой нөхцөлийн төлөвлөгөө - Бүх талын мэдлэг/шалгалтын мэдээлэл

Ил харааны нислэгийн зааварчилгаа - Аэродромын хэсгийн талаарх бүх талын мэдлэг

Хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа - Тухайн аэродромын хэсгийн ажлын талаарх мэдлэг

Дотоод зааварчилгаа - Бүх талын мэдлэг

Тусгайлсан хамтын ажиллагааны журам/санамж бичиг (ялангуяа үйл ажиллагаа эрхлэгч нартай байгуулсан хамтын ажиллагааны журам) - Бүх талын ажлын мэдлэг

Орон нутгийн түгшүүрийн ажиглалтын хамтын ажиллагааны журам - Бүх талын ажлын мэдлэг

Нислэг дагах хяналтын хамтын гэрээ - Бүх талын ажлын мэдлэг

Түвшин Гурав - Unicom үйлчилгээний үндсэн сургалт

Түвшин 3-т суралцагч нь үйл ажиллагааны журмын ойлголтын талаар болон асуултанд хариулах маягаар өөрсдийн үр чадварыг харуулах шаардлага тавигдсан байна.

UNICOM танилцуулга	үйлчилгээний	UNICOM үйлчилгээ гэж юу вэ?
Үүрэг		UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч нь юу хийдэг вэ?
Хариуцлага		Анхаарах үүрэг
Радио-холбоо		Нисэхийн радио-холбооны журам нь Annex 10-ын журмуудын хүрээнд хамаарна.
Цаг		Орон нутгийн болон 24 цагийн цаг - UTC
Хөөрч буух зурвас		ХБЗ гэж юу вэ, хэрхэн ашиглагдах
Аэродромын нислэгийн тойрог		Аэродромын орчим дахь агаарын хөлгийн нислэгийн журам
Аэродром дээр тээврийн хэрэгсэл		Аэродром дээр тээврийн хэрэгсэл барих журам
Аэродромын онцгой нөхцөл		Агаарын хөлгийн онцгой нөхцөлийн үед хариу арга хэмжээ авах
Онцгой нөхцөлийн идэвхижүүлэх арга хэмжээ		Ил харааны нислэгийн төлөвлөгөөний мэдээлэл/шалгалтын мэдээлэл, нэн тэргүүнд авах арга хэмжээ, бүх талын журмын мэдлэг
Нислэгийн хяналтын үйлчилгээ		Ил харааны нислэгийн төлөвлөгөөний мэдээлэл/шалгалтын мэдээлэл, нэн тэргүүнд авах арга хэмжээ, бүх талын журмын мэдлэг
Нийтлэг нөхцөл		Нийтлэг үе шат болон нэр томъёо
Тоног төхөөрөмжийн ашиглалт		Нийлүүлэгч болон шаардлагыг танилцуулах мэдлэг
Бусад үйлчилгээ		Журам, авах арга хэмжээ, давуу эрх

Түвшин Дөрөв - Аэродромын үзлэг

Түвшин 4-т суралцагч нь хамгийн багдаа хоёр удаагийн хяналттай үзлэг хийх болон үндсэн үүргийн талаарх урьдчилсан үзлэгийн тэмдэглэл хийсэн байх шаардлагатай. Үзлэгийн шалгах хуудас нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ болон аль хэсэгт үзлэг хийх ёстойг нарийвчилсан байвал зохино.

Тээврийн хэрэгсэл жолоодох дүрэм/ RTF дуудлага	Агаарын хөлөгт зам тавих -Хурд - Зөв дуудлага
Гадны биет	Танилцуулга
Үзлэгийн давтамж	Хэзээ үзлэг явуулах

Үзлэг хийгдэх хэсэг	Өвс, битүүмж, Гэрэлтүүлэг, Ил харааны ойртолтын налууг заагч, Хашаа, Хаалга, Салхины чиглэл заагч, Бусад навигацгийн тоноглолын аюулгүй байдал
Тоормозлох арга хэмжээ	Хэрхэн тодорхойлох
Шувуу	Хяналт
Үүссэн асуудлын үеийн арга хэмжээ	Асуудал үүссэн үед авах арга хэмжээ
Тэмдэглэл	Шалгалтын хуудсыг бөглөх, үл нийцэл, NOTAM, хуудас

Түвшин Тав - Цаг агаар

Түвшин 5-д суралцагч нь орон нутгийн газар зүйн байрлал, үүл, харагдах цэгийн зай, үүлний байршлын өндөр, үзүүлж байгаа үйлчилгээнд хамааралтай асуултанд хариулах шаардлагатай. Үндсэн үүрэгт хамааралтай хамгийн багадаа хянагдсан 50 тайланг хийсэн байна.

ИНД-174 Гэрчилгээжүүлэлтийн шаардлагаар, цаг агаарын мэдээ нь гэрчилгээжүүлэлтийн холбогдох баримт бичигт тавих шаардлагын дагуу хэрэгжинэ.

Сэдэв нь мэдээллийн түвшинд хамаарна.

Цаг уурын ажиглалт	Танилцуулга
Орон нутгийн газар зүйн байрлал	Тухайн бүс дэх онцлог нөхцөл
Үүл	Мэдэгдэж байгаа газар зүйн байдлыг ашиглах
Тоног төхөөрөмж	Цаг уурын тоног төхөөрөмжийн хэрэглээ
Далайн түвшин, агаарын даралтын утга	Нарийвчлал болон агуулгын чухалчлал
Хамаарах цаг хугацаа	Цагийн мэдээллийн ач холбогдол
Тэмдэглэлийг хадгалах	Маягтууд/Цаг уурын тэмдэглэлийн ашиглалт

Түвшин Зургаа - Цаг агаарын болон мэдээллийн автоматжуулсан дамжуулалт

Түвшин 6-д суралцагч нь тухайн төхөөрөмжийн хэрэглээ, ашиглахаар сонгосон ХБЗ-ыг тодорхойлох, үйл ажиллагааны болон цаг уурын мэдээллийг хугацаанд нь шинэчлэх зэрэг өөрсдийн үр чадварыг харуулах болон аман асуултад хариулах шаардлагатай. Суралцагч нь хамгийн багадаа 50 AWIB үйлчилгээний мэдээллийг хяналттайгаар оруулах болон бэлтгэсэн байх шаардлагатай.

AWIB Үйлчилгээ	Системийн үйл ажиллагааны танилцуулга
Нисэхийн холбооны дамжуулалт	Annex 10, Vol II, Chapter 7 эсхүл хэрэгжилтийг баталгаажуулах журмын талаарх мэдлэг
Тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа

Зааварчилгааны мэдээлэл	Цаг уурын болон аэродромын мэдээллийг цуглуулах
Ашиглахаар сонгосон хөөрч буух зурвас	Ашиглахаар сонгосон ХБЗ-ыг тодорхойлох
Зааварчилгааны өгөгдөл	Үйл ажиллагааны мэдээлэл
Өгөгдлийг оруулах	Хэзээ шинэчлэх, хугацаат шинэчлэл
24 цагийн үйл ажиллагаа	UNICOM хаагдсан үеийн үйл ажиллагаа
AWIB-ийн нөөц төхөөрөмж	Нөөц төхөөрөмжийн үйл ажиллагаа
Тэмдэглэл	Маягтын ашиглалт

Хавсралт С

Аэродромын давтамжид хариулах нэгж

Онцлог шинж чанар

Энэ хуудас нь өргөн хүрээг хамраагүй боловч Аэродромын давтамжид хариулах нэгж /AFRU/-д хэрэглэх зүйлсийг харуулсан болно.

- (a) Хөдөлгөөний дуудлагын тэмдэгтийн гаралт бүхий сонголттой туузан бичигч
- (b) Аэродромын сонголттой алслагдсан хяналт. Дэлхийн аль ч хэсэгт байгаа стандарт компьютер болон утсан холбооны сүлжээний төхөөрөмжөөс мөн компьютер болон сүлжээний төхөөрөмжөөр авах агаарын хэм, салхины чиглэл, хурд гэх мэт мэдээллийн хяналт.
- (c) VHF холбооны радио эсхүл тусдаа орших иж бүрэн системд холбогдох хяналтын нэгжийн хангалт.
- (d) AFRU-ийн үйл ажиллагаанд зориулан зөвшөөрсөн төрлийн радио хувиргагч бүхий тусдаа орших иж бүрэн нэгж.
- (e) 24 цагийн үйл ажиллагаа бүхий дотоод зай хураагуурын нөөцийн хангалт
- (f) Аюулгүйн байдлын сав
- (g) Жирийн бичиглэл болон үхрааж унших шалгалтын дарах товчлуур бүхий энгийн програмчлал
- (h) Тохируулга бүхий бүх цагийн параметр болон үл өөрчлөгдөх санах ой (нууц кодын хамгаалалттай)
- (i) Бичиглэл бүхий микрофон
- (j) Сонголттой хяналтын дуу гаргагч бүхий бичигдсэн мэдээллийн шалгах үхраалт
- (k) Дамжуулах, анхааруулах гэрлэн заалт бүхий зөөвөрлөгчийн завсарлагын цагийн хэмжүүр
- (l) Зай хураагуур дахь нөөцийн гормийн заагч гэрэл
- (m) Үндсэн тэжээлийн заагч гэрэл
- (n) Бичил хяналтын ажиллагааны ОК заагчийн гэрэл (суурилуулсан бол)
- (o) Зөөвөрлөгчийн хүлээн авсаныг заах гэрэл
- (p) Дамжуулах ON заагчийн гэрэл
- (q) Автомат P.A.L. (MBZ/UNICOM дахь давтамж эсхүл бусад бие даасан PAL радио суваг)
- (r) 16 секунд хүртэлх өндөр чанарын дуу гаргагч
- (s) 300 сая секундын 1 KHZ дууны авиа
- (t) Цагийн хэмжүүрийн холболтын эсхүл бусад гадны хяналтын системийн алслагдсан идэвхижүүлэлт/унтраалт
- (u) Програмчлах боломжтой дамжуулалтын хариу өгөх цаг
- (v) Програмчлах боломжтой дамжуулагчийн өмнөх саатлын цаг
- (w) Програмчлах боломжтой зөөвөрлөгчийн салгалтыг болиулах цаг

-
- (x) Програмчлах боломжтой дуу гаргалтын товчлуурын дарах хамгийн бага болон их хугацааны дахин эхлүүлэх цаг заагч
 - (y) Програмчлах боломжтой аэродромтой ойр нөхцөлийн дамжуулалтыг саатуулах цаг заагч
 - (z) Бичил боловсруулагчийн хяналтын хэсэг ба илрүүлэгч болон засварлагчийн тасалдалт
 - (aa) Алслагдсан удирдлага болон хяналтын чадамж
 - (bb) Сонголтот PAL удирдлагын гэрэл (ослоос сэргийлсэн удирдлагатай байх шаардлагатай).

Хавсралт D

Холбооны журам

139.355 (a)(1) UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчийг нислэгийн радио холбооны үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ (FRTO) эсхүл түүнтэй дүйцэхүйц шаардлагын дагуу сургалтанд хамрагдаж үнэлгээ хийгдсэн байхыг шаарддаг. Энэ Хавсралтанд тусгагдсан практик хичээлийн хөтөлбөр болон мэдлэг, чадварын тэмдэглэл нь эдгээр шаардлагад нийцсэн байна.

FRTO-д дүйцэх үйлчилгээг авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээрийн сургалт болон үнэлгээ нь нисгэгчийн үнэмлэхэд тавигддаг ижил шаардлага болох нислэгийн радио-холбооны шаардлагыг хамарсан гэдгийг баталгаажуулах бичгэн тэмдэглэл бүхий баримттай байна.

Практик шалгалтын үйл ажиллагаа нь сургалтын танхимд явагдах нь зөвшөөрөгдсөн байдаг.

Радио- холбооны үйл ажиллагааны тэмдэглэл

Энэхүү тэмдэглэл нь ИНД, ICAO сургалт, салбарын баримт бичиг, аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын стандарт зэрэг шаардлагаас үндэслэгдэн боловсруулагдсан болно. ICAO-ийн сургалт болон Аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын стандартын холбогдох материал нь мэдээлэл болон гарын авлагад заагдсан.

Сэдэв	Жишээ	НААХЗА стандарт	ИКАО
Хяналт	Нисэхийн радио-холбооны төхөөрөмжийн хяналтын зөв залруулга болон тохируулга	15517	052
Ерөнхий радио-холбооны журам		15517	052
Ашиглагдах хэл	Бүх холбоо нь Монгол болон Англи хэл дээр явагдана.	15517	052
Хурд	Тогтмол ярианы хэм	15517	052
Дуу авианы түвшин	Өндөр түвшин бүхий хоолой нь бага түвшинтэй хоолойноос илүү дамжуулагддаг	15517	052
Хэмнэл	Дамжуулагдаж байгаа өгүүлбэр бүр нь ярианаас ярианы хооронд ердийн ярианы бодит хэмнэл нь хадгалагдана.	15517	052
Чанга яригчийн байрлал	Хэрэглэж байгаа чанга яригчийн төрөлд зориулж ам болон чанга яригчийн хоорондох зөв байрлалыг ямагт хадгална.	15517	052
Үгийг үсэглэх	A ALFA AL FAH гэх мэт.	15517	052
Дугаарын дамжуулалт	0 ZE-RO 5 FIFE 9 NINer гэх мэт.	15517	052
Журмын үг болон яриа	ACKNOWLEDGE AFFIRM GO AHEAD WILCO гэх мэт.	15517	052
Цагийн систем	Дамжуулах цагийн арга	15517	052
Холбоог бий болгох	Анхааралтай сонсох	15517	052

Хэрэглэгдэж байгаа давтамж	Станцын сонгох давтамж эсхүл үйлчилгээнд заагдсан ердийн нөхцөлд ашиглагдаж байгаа давтамжууд	15517	052
Холбоо алдагдах	Аэродромын холбогдох өөр давтамжийг хэрэглэх. Радио алдагдах журмын хэрэгжилт	15517	052
Үйлчилгээг тодорхойлох	XX UNICOM	15517	052
Агаарын хөлгийн радио-холбооны дуудлагын тэмдэгт	Нислэгийн дугаараар дагах RT заагч Дуудлагын тэмдэгтийг товчлох шаардлага Төсөөтэй дуудлагын тэмдэгтийн үеийн арга хэмжээ	15517	052
Холбоог солилцох журам	Хаяглагдсан станц Давтамж Хоёр тал бүхий тасралтгүй холбоо Хасалт ROGER OVER THIS IS Read back	15517	052
Залруулга болон давтан унших	Залруулга Давтаарай NEGATIVE.	15517	052
Шалгалт	Дуудагдаж байгаа станцын ID Дуудаж байгаа станцын ID Радио шалгах Давтамж	15517	052
Уншигдах хэмжээ	1 - 5	15517	052
Яаралтай болон аюулын холбоо		15517	052
Тодорхойлолт	Аюул Яаралтай.	15517	052
Аюулын болон яаралтай дохио	MAYDAY PAN	15517	052
Аюулд орсон агаарын хөлгийн авах арга хэмжээ	MAYDAY Хэрэглэгдэж байгаа агаар-газар давтамж Мэдээллийн хэлбэр 121.5 MHz -ийн давтамжийн хэрэглээ	15517	052
Чимээгүй байх шаардлага	Чимээгүй байх үеийн хяналт ЗОГС ДАМЖУУЛАЛТ MAYDAY	15517	052
Бусад бүх станцын авах арга хэмжээ	Тэргүүлэх Давтамжийн хэрэглээ Аюулыг цуцлах/дуусгах Аюулын хөдөлгөөний шилжүүлэлт Зөвшөөрөл Үзүүлэх тусламж	15517	052
Аюулын нөхцөл болон чимээгүй байх шаардлагыг дуусгах	Агаарын хөлгийн, эсхүл газрын станцын авах арга хэмжээ	15517	052
Яаралтай холбоо		15517	052
Яаралтай нөхцөлийг мэдээлж байгаа агаарын хөлгийн авах арга хэмжээ	PAN Хэрэглэж байгаа агаар-газар давтамж Мэдээллийн хэлбэр	15517	052
Бусад бүх станцын	Тэргүүлэх	15517	052

авах арга хэмжээ	Давтамжийн хэрэглээ		
------------------	---------------------	--	--

Үзүүлж байгаа үйлчилгээний хүснэгт

UNICOM-ын шаардлагатай үйлчилгээнүүд	UNICOM-ын үзүүлэх ёсгүй үйлчилгээнүүд
Нисгэгч хүсэлт тависан нөхцөлд, мэдээлж байгаа агаарын хөлгийн ерөнхий байршлыг дамжуулах зэргийг агуулсан мэдээллийн дамжуулалт (энэхүү мэдээллэх явц нь тодорхой болсон мэдээллийг үнэлэх болон саад болох ёсгүй).	Хөдөлгөөний зайчлал, эсхүл хөдөлгөөний хазайлт/зайлсхийлт зэргийг агуулсан нислэгийн хөдөлгөөний мэдээлэл
Ашиглаж байгаа ХБЗ-ны мэдээлэл	Ашиглах ХБЗ-ыг тодорхойлох
ИНД-174-д заасан цаг агаарын үндсэн мэдээний маягтад байгаа цаг агаарын мэдээлэл	ИНД-174-ийн дагуу гэрчилгээжсэнээс бусад тохиолдолд цаг уурын мэдээ
ИНД-139 F Бүлэгт заасан Аэродромын болон цаг агаарын мэдээлэл дамжуулагч (AWIB).	Шуурхай мэдээ өгөх
Аэродромын бүс дэх навигацийн тоноглолд учрах аюулын мэдээлэл (нислэгийн хөдөлгөөний бус мэдээлэл)	ATIS.
Аэродромын бодит үзүүлэлттэй холбоотой аэродромын бусад мэдээлэл	
Онцгой нөхцөлийн идэвхижүүлэх арга хэмжээ	Үйлчилгээнүүдэд түгшүүр зарлах
119.73, 119.121, 135.91 -д заасан агаарын тээвэрлэгчийн шаардлагад нийцэх нислэг дагах хяналтын үйлчилгээ	Нислэгийн төлөвлөлтийн үйлчилгээ